



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Япон Улсын “Яйзү хот”-ын нэрэмжит
гудамж болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, 20.3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүрэг Япон Улсын Шизуко мужийн Яйзү хот хоорондын найрамдалт хамтын ажиллагааг бататган бэхжүүлэх, хоёр орны соёлыг түгээн сурталчлах зорилгоор Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх “Чингэлтэй цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын барилгаас “Эрдмийн задгай театр” хүртэлх чулуун зам бүхий гудамжийг “Яйзү хот”-ын нэрэмжит гудамж болгосугай.

2.Япон Улсын Шизуко мужийн “Яйзү хот”-ын нэрэмжит гудамж болгосонтой холбогдуулан дүүргийн иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Санал уламжлах тухай” 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Т.УЛАМБАЯР

D:/2025-togtool

150109067